



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 340 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсгийн ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар, “Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заварчилгаа өгөх журам”-ыг 6 дугаар хавсралтаар, “Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмуудыг “Таван толгой түлш” ХХК-ийн нийт ажилтан албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Дээрх журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрхзүй, аудитын алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ






М.ГАНБААТАР

Хавсралт №3

	ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СУАЖ-ХБХЖ-007	"БАТЛАА" ГҮЙЦЭТГЭХ БАХИРАЛ М.Ганбаатар
		Хувилбар: 1 Тушаал № А/136	Баталсан өдөр: 2019 он 11 сар 20 өдөр

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

	<p>ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам</p>	<p>СҮАЖ-ХБХЖ-007</p>	<p>БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар</p>
		<p>Хувилбар: 1</p>	<p>Баталсан огноо: 2019 он сар өдөр</p>
		<p>Тушаал №</p>	

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Зорилго.....	4
Хоёр. Хамрах хүрээ	4
Гурав. Хамаарах талууд.....	4
Дөрөв. Үндэслэл	4
Тав. Баримт бичгийн нэр томъёоны тодорхойлолт, товчилсон үг.....	4
Зургаа. Үндсэн шаардлага	6
Долоо. Бүртгэлийг хянах	7
Найм. Оролцогч талуудын үүрэг.....	7
Ес. Хадгалалт	7
Арав. Бүртгэл.....	8
Арван нэг. Холбогдох баримт бичгүүд.....	8

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

Нэг. Зорилго

1.1. Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журмын зорилго нь (цаашид журам гэнэ) “ТТТ” ХХК-ийн ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоонд тусгагдсан зорилтын хэрэгжилт, ХЭМАБ-ын стандартын шаардлагад нийцүүлэн ажиллаж байгааг нотлон харуулах, байгууллага хүссэн үр дүнгээ бий болгож хөтлөхөд оршино.

1.2. Энэхүү баримт бичигт “ТТТ” ХХК-ийн хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоог стандартын дагуу хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэлийг хөтлөх, хаяглах, кодлох, хадгалах, устгах үйл явцыг журамласан болно.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. “ТТТ” ХХК-ийн алба, хэлтэс, цех, хэсэгт хамаарна.

Гурав. Хамаарах талууд

3.1 “ТТТ” ХХК-ийн харъяа салбар үйлдвэр болон гэрээт ажилтнууд, гэрээгээр бараа нийлүүлэгч, ажил гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдэд хамаарна.

Дөрөв. Үндэслэл

Хүснэгт 1

д/д	Баримт бичгийн нэр	Дугаар
1	ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-004
2		

Тав. Баримт бичгийн нэр томъёоны тодорхойлолт, товчилсон үг

5.1 Нэр томъёоны тодорхойлолт

Хүснэгт 2

д/д	Нэр томъёо	Тодорхойлолт
1	Аюул	Хүнийг гэмтээх, эрүүл мэндэд нь хохирол учруулах эсвэл эдгээр нь хосолсон байдлаар учруулах бодит аюул бүхий эх сурвалж, байдал буюу үйлдлийг
2	Аюулыг илрүүлэх	Аюул заналхийлж байгааг тогтоож, түүний үзүүлэлт, шинж чанарыг тодорхойлох үйл явцыг
3	Аюултай тохиолдол	Гэмтэл, эрүүл мэндийн хохирол (хүнд хөнгөнөөс үл хамаарах) эсвэл үхэлд хүргэж болох байсан эсвэл хүргэсэн ажилтай холбоотой тохиолдлыг

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

4	Сонирхогч тал	Тухайн байгууллагын ХЭМАБ-ын гүйцэтгэлийн үр нөлөөтэй байдалд санаа тавьж байгаа буюу түүний үр нөлөөтэй байдалд өртөх, тухайн ажлын байранд эсвэл түүний гадна байгаа ажилтан буюу хэсэг бүлэг хүмүүсийг
5	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ)	Ажлын байранд үйл ажиллагаа явуулж байгаа өөрийн буюу бусад байгууллагын ажиллагсад (түр болон гэрээт ажилтнууд орно), зочид эсвэл бусад ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх эсвэл нөлөөлж болох нөхцөл байдал, хүчин зүйлүүдийг
6	ХЭМАБ –ын удирдлагын тогтолцоо	ХЭМАБ-ын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, ХЭМАБ-ын эрсдэлийг удирдах зорилго бүхий байгууллагын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийг
7	ХЭМАБ-ын зорилт	Байгууллагын ХЭМАБ-ын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны гүйцэтгэлээ сайжруулахын тулд өмнөө тавьсан зорилгыг
8	ХЭМАБ-ын бодлого	ХЭМАБ-ын гүйцэтгэлийн талаар дээд удирдлагаас албан ёсоор тодорхойлсон байгууллагаас баримтлах чиг баримжаа ба чиглэлийг
9	Байгууллага	Өөрийн чиг үүрэг болон удирдлага бүхий төрийн буюу төрийн бус хувийн хэвшлийн компани, корпорац, пүүс, аж ахуйн нэгж, агентлаг, институт эсвэл түүний хэсэг буюу тэдгээрийн нэгдэлийг
10	Сэргийлэх арга хэмжээ	Болзошгүй үл тохирол буюу бусад хүсээгүй байдлын учир шалтгааныг арилгахад чиглэсэн арга хэмжээ
11	Журам	Аливаа үйл ажиллагаа буюу үйл явцыг хэрэгжүүлэхэд зориулан тогтоосон арга
12	Бүртгэл	Хүрсэн үр дүнг бүртгэх буюу үйл ажиллагаа хэрэгжсэнийг нотлох баримт бичиг
13	АМХ	Аюулыг мэдээлэх хуудас

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

5.2. Товчилсон үг

Хүснэгт 3

д/д	Товчилсон үг	Тайлбар
1	ХЭМАБ	Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал
2	АМХ	Аюулыг мэдээлэх хуудас
3	ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс

Зургаа. Үндсэн шаардлага

6.1 Бүртгэлийг хөтлөх, кодлох

- Хууль тогтоомжийн шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлсэн бүртгэл,
- Аюулыг тогтоох, эрсдэлийг үнэлэх, хяналтын арга хэмжээний тухай бүртгэл,(АМХ, эрсдэлийн үнэлгээ, хяналтын 5 аргын талаар)
- ХЭМАБ-н гүйцэтгэлийн мониторингийн бүртгэл, (журмын 3.6.2-т заасан үзүүлэлтүүдийг оруулна)
- ХЭМАБ-н гүйцэтгэлийг хянахад ашигладаг тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга болон техник үйлчилгээний бүртгэл
- Залруулах болон сэргийлэх арга хэмжээний бүртгэл, (Ослын болон сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар, 3 шатны үзлэг, үл тохирлыг залруулах)
- Аудитын хөтөлбөр, төлөвлөгөө, дүгнэлт
- Оролцоо болон зөвлөгөөний бүртгэл,
- Аюултай тохиолдол,түүний мөрөөр авсан арга хэмжээ буюу залруулах арга хэмжээний бүртгэл
- ХЭМАБ-ын талаарх уулзалтын тэмдэглэл,
- Эрүүл мэндийн үзлэгийн тайлан,(Эмнэлгийн хэсэг хариуцан бүртгэнэ).
- Хамгаалах хэрэгслийн техник үйлчилгээ болон туршилтын бүртгэл,(хүчдэлээс тусгаарлах бээлий, ган татлага, таль,нэхмэл татлага...)
- Онцгой байдлын дасгал сургуулилт
- Удирдлагын дүн шинжилгээний бүртгэл.

6.2. Осол, аюултай тохиолдлын бүртгэлийг ХАБ хариуцсан ажилтан улирал тутам хөтөлж гаргасан байна.

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

6.3. “Сургалт”-Компанийн хэмжээнд ХЭМАБ-н чиглэлээр хийгдсэн сургалтууд, ойлголтын баталгааг авсан байдал (шалгалт), сургалтын хуваарь, хөтөлбөр, сургалтын хэрэгцээг тодорхойлсон тухай бүртгэлийг шалгалтын “СУРГАЛТ” нэрэн дор хаягжуулж С үсгээр коджуулж технологийн цехийн дарааллаар 00 индекстэйгээр тухайн оноор тодотгон дугаарлаж бүртгэнэ. Жишээ нь: 1-р үйлдвэр-С-001:2015, 2-р үйлдвэр-002:2015

6.4. Цоож пайзны бүртгэлийн журналыг үйлдвэр бүрийн ээлжийн ахлагч, өдөр бүр хөтөлнө. Үйлдвэр хариуцсан ХАБЭА-н инженерүүд нь бүртгэлийг нэгтгэн сар бүрийн тайланд тусгана.

Долоо. Бүртгэлийг хянах

7.1. Үйлдвэр нэгжүүдийн ХАБЭА-н инженер, ИТА нар өөрсдийн хүлээх үүрэг чиглэлийн дагуу бүртгэлийг хөтлөж түүнийг холбогдох албан тушаалтны хөтлөлтийг зөвшөөрөлгүйгээр гадны болон бүртгэлд нэвтрэх эрхгүй хүнд дамжуулах, танилцуулахыг хатуу хориглоно.

7.2. Бүртгэлийг зөвхөн батлагдсан маягт, гаргасан зааврын дагуу хөтөлнө. .

Тайлбар: Маягтын загварыг баримт бичигт заасан байна.

7.3. Бүртгэлд засвар оруулсан тухай бүрд тухайн эрх бүхий ажилтан гарын үсгээ зурж баталгаажуулна.

Найм. Оролцогч талуудын үүрэг

8.1 Энэхүү журмыг ХАБЭА-н гүйцэтгэлд хамааралтай бүх албан тушаалтан, ажилтнууд мөрдөх үүрэгтэй ба зөрчсөн болон хэрэгжүүлж мөрдөхөд хангалтгүй хандсан албан тушаалтан, ажилтнуудад холбогдох хууль, тогтоомж, байгууллагын дотоод журмын хүрээнд хариуцлага тооцно.

Ес. Хадгалалт

9.1. ХАБЭА-н гүйцэтгэлтэй холбоотой хөтлөгдөж байгаа бүх бүртгэлийг аюулгүй, найдвартай газарт хадгална. Үүнд:

9.1.1. Гал, ус зэрэгт автах, механик гэмтэлд өртөж болзошгүй газраас хол хадгалах

9.1.2. Зөвшөөрөлгүй хүн бүртгэлд нэвтрэхээс сэргийлж цоожтой шкафанд хадгална.

9.1.3. Цахим хэлбэрээр хадгалах нөхцөлд тусгайлан мэдээллийн сан үүсгэн, нууцлалыг өндөр төвшинд шийдвэрлэсэн байх ба бүртгэл гэмтэж устгахаас сэргийлж дахин сэргээх боломжийг бүрдүүлэх зорилгоор уян дискэнд хуулбарлан архивд хадгална.

9.2. Шаардлагатай материалуудыг архивын тухай хуулийн хүрээнд архивд хадгалуулна.

ХЭМАБ-ын бүртгэлийн хяналтын журам	СҮАЖ-ХБХЖ-007
	Хувилбар: 1

Арав. Бүртгэл

Хүснэгт 5

д/д	Бүртгэлийн нэр	Бүртгэлийн дугаар
1	ХАБЭА-н урьдчилсан зааварчилгаа	АШБ-ХХ-01
2	ХЭМАБ-н урьдчилсан зааварчилгаа /шинэ ажилтан/ дадлага	АШБ-ХХ-02
3	ХЭМАБ-н зөрчлийн бүртгэл	АШБ-ХХ-03
4	ХЭМАБ-ын шинэ ажилтны сургалт шалгалтын бүртгэл	АШБ-ХХ-04
5	ХЭМАБ-ын нийт ажилтны сургалтын бүртгэл	АШБ-ХХ-05
6	ХЭМАБ-н Ээлжит бус зааварчилгааны бүртгэл ХАБЭА-н хяналтын хэсэгт ИТА өгөгдөнө.	АШБ-ХХ-06
7	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтнуудын бүртгэл	АШБ-ХХ-07
8	Хурлын бүртгэл	АШБ-ХХ-08
9	Осол гэмтлийн бүртгэл	АШБ-ХХ-09
10	Ерөнхий зөвшөөрлийн бүртгэл	АШБ-ХХ-10
11	Хариуцлагын төлбөр ноогдуулсан ажилтнуудын бүртгэл	АШБ-ХХ-11
12	Зочны зааварчилгааны бүртгэл	АШБ-ХХ-12
13	Аюул, Аюултай тохиолдлын бүртгэл	АШБ-ХХ-13
14	Яаралтай тусламжийн нэгжийн үзлэгийн бүртгэл	АШБ-ХХ-14
15	Яаралтай тусламжийн нэгжийн эм тариа зарлагын бүртгэл	АШБ-ХХ-15
16	Яаралтай тусламжийн нэгжийн рапортын бүртгэл	АШБ-ХХ-16

Арван нэг. Холбогдох баримт бичгүүд

Хүснэгт 6

д/д	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн дугаар
1	ХАБЭА-н баримт бичиг боловсруулах журам	СҮАЖ-ХБББЖ-0012
2	Баримт бичиг нягтлан шалгах комисс	СҮАЖ-